

ОЮУТНЫ ДЭМЖИХ БҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР НӨЛӨӨ

*Т. Оюунбилэг
Доктор (Ph.D)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

oyunbileg@must.edu.mn

Хураангуй: Монголын томоохон их сургууль болох ШУТИС нь “олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөгжлийн тулгуур, нээлттэй их сургууль болж, насан туридаа өөрийгөө хөгжүүлэгч суралцахуйн зан төлөв бүхий мэргэжилтэн судлаачдыг бэлтгэнэ” гэсэн алсын хараа, үнэт зүйлээ тодорхойлсон бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхийн тулд оюутны соёл, хүмүүжлийн ажлыг хэрхэн үр бүтээлтэй зохион байгуулах вэ? гэдэг асуудлын хүрээнд тодорхой бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын практик, онол, арга зүйн загваруудыг харьцуулан судалж, оюутны дэмжих бүлэгт үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний загварыг боловсруулж, практик үр нөлөөг үнэлэх явдал юм. Оюутны дэмжих бүлгийн үйлчилгээний үр дүнг үнэлэхэд харилцааны ур чадвар хэсгийн дунджаар 0.7, өөртөө итгэх итгэл хэсгийн дунджаар 0.3, төлөвлөлт ба хувийн зохион байгуулалт 0.4, асуудлаа олж харах чадвар 0.2 пунктээр өссөн байна. Мөн туршилтын дараах судалгаагаар тулгамдсан байдлаа илэрхийлэхээс зайлсхийх байдал 2.0 хувиар, залхуурал 15.0 хувиар, нойргүйдэл 3.0 хувиар тус тус буурсан байна.

Түлхүүр үгс: оюутан, дэмжих бүлэг, бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын практик

УДИРТГАЛ

Шинэ мянганы залуучуудын тэр дундаа аж үйлдвэржилтийн IV хувьсгал ба үе тэнгийнхний онцлогийг харьцуулан үзэхэд дижитал болон социаль сүлжээний нөлөөгөөр олон талт харилцаа, шинэчлэлт, өөрчлөлтийг чухалчилсан үнэт зүйлтэй, хязгааргүй, өвөрмөц онцгой хэрэглээтэй Z үеийн нэгэн томоохон төлөөлөл болох оюутан залуучуудын тоо тасралтгүй өсч байна. Ийнхүү үе хоорондын ялгаа ихэсч буй энэ нөхцөлд хуучин нөхцлөөр оюутан залуучуудын асуудлыг тайлбарлах аргагүй юм.

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2000-2001 оны хичээлийн жилд 172 байсан бол 2018-2019 онд 94 болж, 45.3 хувиар буурч, тэдгээрт суралцагсдын тоо 157600 болж 1.9 дахин өссөн. Дээд боловсролын сургалтын 94 байгууллагын 37.2 хувь нь их сургууль, 52.1 хувь нь дээд сургууль, 7.5 хувь нь коллежийн ангилалд багтаж, 3.2 хувь нь гадаадын салбар сургууль байна. Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсийн харьцааг сүүлийн 20 жилийн байдлаар авч үзэхэд эмэгтэй 74.3 хувь болж тасралтгүй өсч байна [1].

Их сургууль бүр өөрийн алсын хараа зорилго, стратегиа тодорхойлсон байдаг. Монголын томоохон их дээд сургууль болох ШУТИС нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөгжлийн тулгуур, нээлттэй их сургууль болж насан туршдаа өөрийгөө хөгжүүлэгч суралцахуйн зан төлөв бүхий мэргэжилтэн судлаачдыг бэлтгэхээр алсын хараа, үнэт зүйлсээ тодорхойлж, азийн шилдэг их дээд сургууль болох алс хэтийн чиг хандлагатай байна. Энэхүү алсын хараа, зорилгодоо хүрэхийн тулд юунд анхаарах хэрэгтэй байна вэ? Технологийн эрин үед шаардлагатай байгаа хүний нөөц, мэргэжилтнүүдийг дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйцээр бэлтгэн гаргахад хэрхэн анхаарах вэ? Монголын их дээд боловсролын тогтолцоо хурдацтай өргөжин тэлж байгаа энэ цаг үед аж үйлдвэрлэлийн салбар, ажил мэргэжлийн эрэлт хэрэгцээний байдалтай хэрхэн уялдаж байгаа вэ? гэх мэтчлэн олон асуулт дээд боловсролын салбарт байсаар байна. Иймд оюутан залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг судлан тодорхойлж, дэмжих бүлгийн үйлчилгээг хүргэх боломж, арга замыг эрж хайх зайлшгүй шаардлагатай байна. Судалгааны судлагдахуун нь ШУТИС-д суралцаж буй 17-22 насны оюутнууд байсан. Хамрах хүрээ нь оюутны асуудалд суурилсан дэмжих бүлгийн үйлчилгээний загварыг турших ажлын хүрээнд ШУТИС-ийн оюутны дэмжих бүлэгт хамрагдсан оюутнуудыг хамруулсан.

Судалгааны зорилго. Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын практик, онол, арга зүйн загваруудыг харьцуулан судалж, оюутны дэмжих бүлэгт үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний загварыг боловсруулж, практик үр нөлөөг үнэлэх явдал юм. Оюутны дэмжих бүлгийн үйлчилгээний үр нөлөөг туршилтын аргаар үнэлсэн. Түүнчлэн судалгааны мэдээлэл цуглуулах болон шинжилгээ хийх эмпирик аргын хувьд тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн. Судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга нь асуулга, баримт бичиг судлах, ажиглалт, бүлгийн ярилцлага байсан бөгөөд мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ чанарын мэдээлэлд категоричлол, харьцуулалт, загварчлал, хэв маягчлалын, харин тоон мэдээлэлд статистик шинжилгээ хийсэн. Судалгааны ажлын хүрээнд боловсруулсан оюутны дэмжих бүлгийн үйлчилгээний загварыг ерөнхий боловсролын сургууль, асрамжийн газар, их, дээд сургуульд ашиглах практик ач холбогдолтой.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Энэхүү судалгааны ажлыг бүхэлд нь бүтэц, үүргийн онолын хүрээнд тайлбарлаж болох бөгөөд их сургууль боловсролын институт болохын хувьд оюутан залуучууд нийгмийн системийн бие даасан категори болохын хувьд тэдгээрийн асуудал болон хэрэгцээ нь оюутны бүлгийг зохион байгуулах үндэслэл болохыг энэхүү онолын үзэл баримтлал тодорхойлж байна. Энэхүү

сэдэвт ажлыг салбар дундын хандлагаар гүйцэтгэсэн бөгөөд социологи, сэтгэл судлал, нийгмийн ажлын онол, арга зүйг хослуулан тайлбарлаж байна.

Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын практик, онол [2], арга зүйн загваруудыг харьцуулан судалж, оюутны дэмжих бүлгийг зохион байгуулах загварыг үндэслэж байна.

1. Стеклер, Хабли BASNEF загварын хэрэгжүүлэгч хүчин зүйлийн хувьд интервенцийн стратегиудаас танин мэдэхүйн болон оролцооны интервенцийн стратегийг оюутны дэмжих бүлгийн үйлчилгээний загвар боловсруулахад ашиглаж байна [3].

2. Оюутанд туслах хөтөлбөр [4] болон Оюутны суурь чадварын оношилгоо (K-CESA)-д суурилсан оюутанд чиглэсэн хөтөлбөрүүд [5] нь гадаадын их сургуулийн веб хуудсанд албан ёсоор байршсан байх бөгөөд оюутан сайн дурын үндсэн дээр шаардлагатай үйлчилгээг авах боломжтой байдаг байна. Иймд судалгааны ажлын сэдэв, зорилготой уялдуулан ШУТИС-д энэхүү үйлчилгээг практикт санал болгох нь зүйтэй гэж үзэж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Оюутны дэмжих бүлгийг зохион байгуулах практик загварыг боловсруулж, нийтлэг үзэл баримтлал, шаардлага, хууль, эрх зүй, зарчим, ур чадварууд, үйлчилгээний арга зүйг тодорхойлсны дагуу 2020 оны 8 сараас 2021 оны 2 сар хүртэлх хугацаанд дэмжих бүлгийг зохион байгуулсан.

Дэмжих бүлгийг санаачлан зохион байгуулах зар, мэдээллийг 2020 оны 1 сараас эхлэн ШУТИС-ийн БУХС-ийн Оюутны Зөвлөл, ШУТИС-ийн нийгмийн ажлын нэгдсэн групп, “Миний ном” ШУТИС гэсэн цахим хуудсуудаар дамжуулан түгээсэн. Гэвч цар тахлын хөл хорионы улмаас энэхүү үйл ажиллагааг эхлүүлэх ажил хойшлогдож, хүндрэлтэй асуудлууд тулгарсан.

Дэмжих бүлгийн туршилтын ажлыг нөхцөл байдалтай уялдуулан “Миний ном” клубын гишүүд болон бусад оюутнуудад хүсэлт илгээсний үндсэн дээр нийт 10 оюутантай эхлүүлсэн. Дэмжих бүлгийн үйлчилгээг долоо хоногт 1 удаагийн 90 минутаар төлөвлөсөн.

Хүснэгт 1. Дэмжих бүлгийн уулзалтууд

№	Үйл ажиллагаа	Арга техник
1	Танилцах, Бүлгийн дүрэм хэлэлцэх Гэрээ байгуулах Туршилтын өмнөх судалгаа авах	-Ярилцлага хийх, -Зорилгот бүлгийн гишүүдийг идэвхжүүлэх -Оролцоог нэмэгдүүлэх Гэрийн даалгавар: Амьдралын 8 хурд дасгал
2	Бүлгийг хөгжүүлэх Асуудал ба хэрэгцээг тодорхойлох	-Бүлгийн хэлэлцүүлэг Нөөц ба хэрэгцээний зураглал хийх Оролцооны аргаар давуу тал, нөөцийг илрүүлэх техник Гэрийн даалгавар: Давуу талыг илрүүлэх техник

3	Үнэт зүйлийг хандлагыг тодорхойлох-хэлэлцүүлэг	Үнэт зүйл суррилсан практикийн “3 үг дасгал” Оюуны шуурга Бүлгийн хэлэлцүүлэг
4	“Үнэт зүйлийн ялгаатай байдал ба шийдвэр” хэлэлцүүлэг	Шийдвэр гаргах техник Бүлгийн хэлэлцүүлэг
5	Зан үйлийн засал Цахим уулзалт	СВТ-танин мэдэхүй, зан үйлийн заслын схем Бүлгийн хэлэлцүүлэг Гэрийн даалгавар: СВТ дасгалаа ажиллах
6	Цагийн менежмент ба хувийн санаачлагыг хөгжүүлэх Цахим уулзалт	Хувийн санаачлагыг хөгжүүлэх дасгал Бүлгийн хэлэлцүүлэг Гэрийн даалгавар: хувийн санаачлагыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах Мандала будах
7	Стрессээс урьдчилан сэргийлэх Цахим уулзалт	Амьсгалын дасгалууд Цаас урах Мандала будах Мэдрэмжээ илэрхийлэх Бүлгийн хэлэлцүүлэг Гэрийн даалгавар: Ирээдүйн төлөвлөлт хийх
8	Ирээдүйн төлөвлөгөө гаргах Төгсгөлтэй ажиллах Туршилтын дараах судалгаа авах Цахим уулзалт	Ирээдүйн төлөвлөлт хийх нь SWOT шинжилгээ Бүлгийн хэлэлцүүлэг

Оюутны дэмжих бүлгийн үйл ажиллагааны үр дүнг дараах аргуудаар тодорхойллоо. Үүнд:

1. Бүлгийн хэлэлцүүлэг
2. Ажиглалтын тэмдэглэлд дүн шинжилгээ хийх
3. Асуулга (туршилтын өмнөх ба дараах)
4. Сэтгэл ханамжийн үнэлгээ.

Бүлгийн хэлэлцүүлгийн үр дүн. Дэмжих бүлгийн гишүүдийн 75.0 хувь нь эмэгтэй, 25.0 хувь нь эрэгтэй оюутан байсан бөгөөд 60.0 хувь нь хотын харъяалалтай байна. Тэдгээрийн эцэг эхчүүдийн 80.0 хувь нь амьжиргааны түвшин нь дунд зэрэг, 60.0 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Оюутнуудын 85.0 хувь нь сонгосон мэргэжилдээ сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн бөгөөд 30.0 хувь нь сайн суралцаж байна.

Дэмжих бүлгийн үйл ажиллагаанд хамрагдсанаар нийтгэч байх, бусдад туслах, шинийг санаачлах, бусдын сонсохыг чухалчлах байдал өсөхийн зэрэгцээ чөлөөт цагаараа ном унших, блог сонсох, кино үзэх, спортоор хичээллэх, подкаст сонсохыг чухалчлах хандлагатай байна.

Дэмжих бүлгийн 8 удаагийн уулзалтын дараа бүлгийн гишүүдийн ярилцлагын явцад SWOT шинжилгээ хийхэд дараах үр дүн гарлаа.

Давуу тал нь:

- Асуудал шийдвэрлэх чадвар:
 - Асуудлаа шийдвэрлэх арга замаа олсон.

- Асуудал хүн бүрт тулгардагийг ойлгосон.
- Асуудлаа ярилцаж хамтдаа шийдвэр гаргасан.
- Асуудлаа хойш тавихаа больсон.
- Өөртөө итгэх итгэл:
 - Ангийнхантайгаа ярилцдаггүй. Ичдэг байсан ч одоо биеэ барихаа багасгасан.
 - Сандрал багассан.
- Харилцааны ур чадвар:
 - Бие биенээ ойлгож, харилцан суралцсан.
 - Бусад оюутнуудтай ярилцдаг болсон.
 - Идэвх, оролцоо:
 - Идэвх, санаачилга нэмэгдсэн.
 - Багаар ажиллах чадвар
 - Багаар ажиллах чадвар

Сул тал нь:

- Бүлгийн зарим гишүүдийн идэвх муу.
- Зарим оюутнууд асуудлаа илэн далангүй ярихаас зайлсхийж байсан.
- Ковидтой холбоотойгоор уулзалт дундаа завсарласан.

Сайжруулах боломж, арга зам нь:

- Уулзалтуудыг тогтмолжуулах
- Асуудлыг олон талаас нь харах аргад суралцах
- Өөрийгөө илэрхийлэхэд суралцах
- Нөөцөө олж харах боломжийг бүлдүүлэх
- Манлайлагчтай болох
- Цагаа баримтлах
- Оюутнуудад дэмжих бүлгийн талаар зар, мэдээлэл хүргэх
- Манлайлагч нар дэмжих бүлгийг зохион байгуулах
- Онлайнаар судалгаа авах
- Бүлгийн гишүүдийг идэвхжүүлэх


Дэмжих бүлгийн үйл ажиллагааны эрсдэл нь:

- Манлайлагч оюутнууд дэмжих бүлгийг хөгжүүлэх мэдлэг, чадвар дутмаг
- Зөвхөн оюутнуудаас бүрдсэн уулзалтууд биш учраас чин сэтгэлийн яриа үүсэхгүй.
- Ковидын хөл хорионоос болж цаашид үргэлжлэх боломжгүй, манлайлагч оюутнууд төгсөөд явчихна.
- Дэмжих бүлгийн талаар оюутнууд ямар ч ойлголтгүй байгаа зэргийг тодорхойлжээ.

Ажиглалтын тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээ. Оюутны дэмжих бүлгийн уулзалтыг үнэт зүйлд суурилсан практик загварт үндэслэн боловсруулсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үйл явцын тэмдэглэлийг “Асуудалд чиглэсэн SOAP тэмдэглэлийн маягт [6] ашиглан хөтөлсөн. Нийт 9 удаагийн уулзалтын 90 үйл явцын тэмдэглэлд дараах байдлаар анализ хийлээ.


Бүлгийн гишүүдийн илэрхийлж буй тулгамдсан асуудлыг дэмжих бүлгийн туршилтын өмнө ба дараа нь харьцуулан үзэхэд дэмжих бүлгийн туршилтын өмнө нь тулгамдсан асуудлаа илэрхийлэхээс зайлсхийх байдал, залхуурал, сэтгэл санаагаа хямрах асуудал тулгамдаж байсан бол дэмжих бүлгийн үйлчилгээний дараа тулгамдсан байдлаа илэрхийлэхээс зайлсхийх байдал 2.0 хувиар, залхуурал 15.0 хувиар, нойргүйдэл 3.0 хувиар тус тус буурсан байна. Мөн санхүүгийн асуудал тулгамдаж байгааг олж харах байдал 12.0 хувиар өссөн байна.

Зураг 1. Дэмжих бүлгийн туршилтын үр нөлөө



Оюутны дэмжих бүлгийн үйлчилгээний үр нөлөөг харилцааны ур чадвар, өөртөө итгэх итгэл, төлөвлөлт ба хувийн зохион байгуулалт, асуудлаа олж харах чадвар гэсэн 4 шалгуураар хэмжсэн бөгөөд харилцааны ур чадвар хэсгийн дунжаар 0.7, өөртөө итгэх итгэл хэсгийн дунджаар 0.3, төлөвлөлт ба хувийн зохион байгуулалт 0.4, асуудлаа олж харах чадвар 0.2 пунктээр өссөн байна.

Зураг 2. Дэмжих бүлгийн үйлчилгээний туршилтын үр дүн



Дэмжих бүлгийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаагаар үйлчилгээний сэтгэл ханамж өндөр, практик асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээгээр тусалж чадсан, туслалцаа хэрэгтэй бол эргэж холбогдох боломжтой, хүсэн хүлээсэн үйлчилгээгээ авч чадсан гэсэн үр дүнг илрүүлсэн. Сэтгэл ханамжийн судалгааны 8 шалгуур асуултын дундаж 3.3 байгаа нь зохих үр дүнгээ өгснийг харуулж байна.

Иймээс ШУТИС-ийн оюутны дэмжих бүлгийг зохион байгуулсан нь оюутны үнэт зүйлийн нийгэмшилтэд нөлөөлж, өөрийн үнэт зүйлээ илүү тодорхой тодорхойлохын зэрэгцээ хамт суралцаж буй оюутнуудтай туршлагаа хуваалцах, бүлэг дотор биеэ авч явах, өөрийгөө илэрхийлэх чадвар хөгжихөд зохих хэмжээнд нөлөөлсөн байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Тус судалгаанд зөвхөн ШУТИС-ийн БУХС-ийн оюутнууд хамрагдсан бөгөөд нэг удаагийн дэмжих бүлгийн үйлчилгээний үр дүнд тулгуурласан улсын болоод хотын бүх их, дээд сургуулийг төлөөлж чадахгүй. Түүнчлэн судалгаа нь зөвхөн дэмжих бүлгийн үйлчилгээнд хамрагдсан оюутнуудаас мэдээлэл авснаараа хязгаарлагдмал байна.

Хэдийгээр тус судалгаа нь дээрх хязгаарлагдмал талтай ч, тодорхой хэмжээгээр оюутны асуудал, хүндрэлийг өөрсдийн оролцонд суурилсан дэмжих бүлгээр дамжуулан шийдвэрлэх асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлахад дэмжлэг болж байна.

ДҮГНЭЛТ

1. Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын практик, онол, арга зүйн загваруудыг харьцуулан судалж, оюутны дэмжих бүлэгт үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний загварын нотолгоо бүхий үндэслэлийг боловсруулсан бөгөөд практик үр нөлөөг үнэлсэн.

2. Оюутны дэмжих бүлгийн үйлчилгээний үр нөлөөг харилцааны ур чадвар, өөртөө итгэх итгэл, төлөвлөлт ба хувийн зохион байгуулалт, асуудлаа олж харах чадвар гэсэн 4 шалгуураар хэмжсэн бөгөөд харилцааны ур чадвар хэсгийн дунжаар 0.7, өөртөө итгэх итгэл хэсгийн дунджаар 0.3, төлөвлөлт ба хувийн зохион байгуулалт 0.4, асуудлаа олж харах чадвар 0.2 пунктээр өссөн байна. Мөн дэмжих бүлгийн үйлчилгээний дараа тулгамдсан байдлаа илэрхийлэхээс зайлсхийх байдал 2.0 хувиар, залхуурал 15.0 хувиар, нойргүйдэл 3.0 хувиар тус тус буурсан байна.

3. Практик загварыг цаашид хөгжүүлэхийн тулд дараах санал, зөвлөмж дэвшүүлж байна. Үүнд:

- Мэргэжлийн нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх;

- Тогтвортой хөрөнгө санхүү нь ихэнх хөтөлбөрүүдийн хувьд амжилттай хэрэгжихийн гол үндэс нь болдог тул төсөв санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Оюутны соёл, үйлчилгээний албаны оюутны нийгмийн ажил болон нийгмийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд энэхүү сайн туршлагыг практикт ашиглах;
- Олон улсын их сургуулийн жишигт нийцүүлэн энэхүү загварыг тус сургуулийн веб хуудсанд албан ёсоор байршуулах замаар оюутны оролцоог нэмэгдүүлэх боломжтой.
- Оюутны соёл, үйлчилгээний албаны дэргэд “судалгааны төв” байгуулж, оюутны нийгмийн асуудлын мэдээллийн сан бүрдүүлэх зэргийг санал болгож байна.

НОМЗҮЙ

[1] *Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212. (2021)*

[2] *S.Rengasamy. (2010). Social group work.*

[3] *Мира Б. Рейчел Карнийж. НҮБ. ХАС. Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо, 2008*

[4] *http://www.ubalt.edu.com. Retrieved from http://www.ubalt.edu/about-ub/offices-and-services/dean-of-students/sap/.*

[5] *Сун Ин Тэг, С.Туяа. Нийгмийн хөгжил: асуудал, шийдэл сэтгүүл. Их, дээд сургуулийн оюутны суурь чадварыг хөгжүүлэх асуудалд, 2019*

[6] *А.Батхишиг. Сум, баг, хорооны нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага, 201*